



## ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2024 оны 06 дугаар сар

**АУДИТЫН СЭДЭВ: АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН  
СОНГУУЛИЙН ТОЙРОГТ НАМ, ЭВСЭЛ, НЭР  
ДЭВШИГЧЭЭС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ДЭЭД  
ХЭМЖЭЭ ТОГТООХ**



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/04

Эрдэнэт

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар “Аргачлал батлах тухай” тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.1, 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэг нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 468.3 сая төгрөгөөр тогтоосугай.

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг нэгдүгээр, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэг нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг хоёрдугаар, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус тогтоосугай.

3.Энэхүү тушаалаар тогтоосон зардлын дээд хэмжээг олон нийтэд мэдээлэхийг ахлах аудитор /Г.Оргилмөрөн/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Буян-Ундрах/-т даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

D:\my doc \bichig hereg\ tushaal \ 2024.doc

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/04 дүгээр тушаалын Нэгдүгээр хавсралт

Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрогт нэг нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээ

Тойргийн дугаар	Тойргийн нутаг дэвсгэр	Зардлын дээд хэмжээ /сая төгрөгөөр/
1	Баян-Өндөр сум, Зэст баг	27.0
2	Баян-Өндөр сум, Оюут баг	29.5
3	Баян-Өндөр сум, Уурхайчин баг	28.7
4	Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг	29.4
5	Баян-Өндөр сум, Уртбулаг баг	25.6
6	Баян-Өндөр сум, Согоот баг	28.2
7	Баян-Өндөр сум, Дэнж баг	26.2
8	Баян-Өндөр сум, Бүрэнбүст баг	24.9
9	Баян-Өндөр сум, Шанд баг	23.2
10	Баян-Өндөр сум, Наран баг	24.8
11	Баян-Өндөр сум, Цагаанчулуут баг	26.9
12	Баян-Өндөр сум, Булаг баг	24.1
13	Баян-Өндөр сум, Баянцагаан баг	25.5
14	Баян-Өндөр сум, Говил баг	24.3
15	Баян-Өндөр сум, Рашаант баг	24.1
16	Баян-Өндөр сум, Эрдэнэ баг	26.8
17	Баян-Өндөр сум, Баянбулаг баг	24.6
18	Баян-Өндөр сум, Их залуу баг	22.5
19	Баян-Өндөр сум, Даваат баг	23.6
20	Баян-Өндөр сум, Уртын гол баг	24.2
21	Баян-Өндөр сум, Яргуйт, Малчин баг	33.6
22	Баян-Өндөр сум, Найрамдал баг	22.8
23	Баян-Өндөр сум, Чандмань баг	22.1
24	Баян-Өндөр сум, Чингэл баг	21.4
25	Баян-Өндөр сум, Баян-Овоот баг	22.6
26	Жаргалант сум	39.4

Орхон аймаг дахь Төрийн аудитын  
газрын дарга, тэргүүлэх аудиторын  
2024 оны 06 дугаар сарын 28-ны  
өдрийн А/04 дүгээр тушаалын  
Хоёрдугаар хавсралт

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвслээс  
зарцуулах зардлын дээд хэмжээ

81174339  
0AA0073 9042806

д/д	Сумын нэр	Зардлын дээд хэмжээ /сая төгрөгөөр/
1	Орхон аймгийн Баян-Өндөр сум	186.7
2	Орхон аймгийн Жаргалант сум	51.0

Орхон аймаг дахь Төрийн аудитын  
газрын дарга, тэргүүлэх аудиторын  
2024 оны 06 дугаар сарын 28-ны  
өдрийн А/04 дүгээр тушаалын  
Гуравдугаар хавсралт

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрогт нэг нэр  
дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээ

Тойргийн дугаар	Сумын нэр	Тойргийн нутаг дэвсгэр	Зардлын дээд хэмжээ /сая төгрөгөөр/
1	Баян-Өндөр сум	Зэст баг	14.7
2		Оюут баг	16.8
3		Уурхайчин баг	16.4
4		Хүрэнбулаг баг	16.5
5		Уртбулаг баг	14.6
6		Согоот баг	15.9
7		Дэнж баг	15.1
8		Бүрэнбүст баг	13.9
9		Шанд баг	9.6
10		Наран баг	11.2
11		Цагаанчулуут баг	12.3
12		Булаг баг	10.5
13		Баянцагаан баг	13.9
14		Говил баг	10.7
15		Рашаант баг	13.2
16		Эрдэнэ баг	15.2
17		Баянбулаг баг	11.0
18		Их залуу баг	12.6
19		Даваат баг	12.7
20		Уртын гол баг	10.6
21		Яргуйт, Малчин баг	13.8
22		Найрамдал баг	9.2
23		Чандмань баг	8.5
24		Чингэл баг	7.9
25		Баян-Овоот баг	8.9
1	Жаргалант сум	Улаантолгой баг	11.9
2		Жаргалант баг	12.4
3		Дулаан-Уул баг	12.2

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалт, сан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/100 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын 2024 онд гүйцэтгэх аудитын сэдэв”-ийг үндэслэн аудитыг гүйцэтгэлээ.

### Аудитын зорилт

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэлээ.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, нийтэд мэдээлэх,
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, нийтэд мэдээлэх,
- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, нийтэд мэдээлэх.

### Аудитын хамарсан хүрээ

Аудитад Орхон аймгийн сонгуулийн тойрог, хэсгийн байршил, өрхийн болон сонгогчийн тоог эрх бүхий байгууллагаас гаргасан судалгаа, мэдээлэл, хуулиар зөвшөөрсөн сонгуулийн сурталчилгаанд зарцуулах зардлыг мэдээлэл, үнэ тариф зэргийг шаардлагатай эх сурвалжаас авч ашиглав.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хууль, холбогдох эрх зүйн баримтад заасан 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох, нийтэд мэдээлэхтэй холбоотой аймгийн Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Статистикийн хэлтэс, улс төрийн намууд болон холбогдох байгууллагуудыг хамруулсан.

### Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав. Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

### Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах хянан удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

## **Ерөнхий мэдээлэл**

Аймгийн 2020 оны ээлжит сонгуулийн оролцох нам, эвсэл болон бие даагчийн сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг Орхон аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын А/15 дугаар тушаалаар нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд 462.7 сая төгрөг, Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд 187.8 сая төгрөг, Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд 52.7 сая төгрөгөөр тогтоожээ. Харин нэр дэвшигчийн зарцуулах зардлын дээд хэмжээг тухайн тойргоос хамааруулан 9.0 сая төгрөгөөс 34.6 сая төгрөгөөр тогтоосон байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуулийг өөрчлөөгүй бөгөөд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн өөрчлөлтөөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоо 41, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоо 21, 29 болсон байна.

Сонгуулийн зардлыг тооцоолохдоо Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуулийн 35-46 дугаар зүйлийг шалгуур болгосон бөгөөд Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар “Аргачлал батлах тухай” тогтоолын дагуу тооцооллыг хийсэн.

**Өрхийн тоо, сонгогчийн тоог харгалзан сонгуулийн зардлын тооцоолол хийх эрх зүйн зохицуулалттай байна.**

Нам, эвсэл болон нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтооход шаардлагатай өрхийн тоог 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх аймгийн Статистикийн хэлтсийн тоогоор, сонгогчийн тоог 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн байдлаарх Улсын бүртгэлийн ерөнхий газрын тоогоор тооцсон байна. Эдгээр тоон мэдээлэлд үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тойрог, мандатыг тогтоосон байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.5 дахь хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4 дэх заалтыг заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 19/05 дугаар “Сонгуулийн тойрог, тойрогт ногдох мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” тогтоолоор 26 тойрогт 41 мандаттай байхаар баталжээ.

**Улсын Их Хурлын сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтоох аргачлалыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтооход мөрдсөн ба сонгуулийн зардлыг өмнөх сонгуулийн зардлын дээд хэмжээнээс бууруулах чиглэлийг баримтлалаа.**

Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээдийн зардлын дээд хэмжээг тогтооходоо Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуулийн 38-46 дугаар зүйлийг шалгуур болгон, ҮАГ-ын УИХ-ын сонгуулийн зардал тооцсон дундаж үнийн дүнгээс тооцлоо.

## **ДҮГНЭЛТ**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэг нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 468.3 сая төгрөгөөр, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 21.4-39.4 сая төгрөгөөр тогтоосон.

Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэг нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 186.7 сая төгрөгөөр, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 7.9-16.8 сая төгрөгөөр тогтоолоо.

Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэг нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 51.0 сая төгрөгөөр, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 12.0 сая төгрөгөөр тогтоосон.